

**ХҮН АМИНЫ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ШИЙТГҮҮЛЖ, ШШГЕГ-ЫН ХАРЬЯА  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОРИХ 0407 ДУГААР АНГИД ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЯЛТНУУДЫН  
ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛД ХИЙСЭН  
СУДАЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС**

2012.02.07

Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Хүн амины гэмт хэрэгт ял шийтгүүлж, хорих 407 дугаар ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөө хэрхэн хангагдаж байгаа эсэх болон тэдгээрийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хэрэгт холбогдож байгаа тохиолдолд дүн шинжилгээ хийж судалгааны дүнг гарган холбогдох байгууллагуудад санал зөвлөмж тавих, тодорхой арга хэмжээ авахуулах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2012 оны 1 дүгээр сарын ...-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа эмэгтэйчүүдийн хорих 0407 дугаар ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн дунд судалгааны ажил зохион явууллаа.

Судалгааг Комиссын гишүүн Ж.Дашдорж ахлан, референт Б.Батаа, Т.Ихтамир, Г.Агар-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй явуулав.

Судалгааны ажлыг явуулахдаа ялтнуудаас санал асуулга авах, ярилцлага зохион байгуулах, хорих ангийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудаас амаар болон бичгээр тайлбар авах хэлбэрээр явууллаа.

**Хоёр. Судалгааны хүрээ**

Судалгааг дор дурдсан хүрээнд явуулав. Үүнд:

1. Ялтнуудын нас, хэргийн зүйл анги, шүүхээс ногдуулсан ялын хэмжээ, ял эдэлсэн хугацаа зэрэг хувийн мэдээллийг тодруулах.
2. Гэмт хэрэгт шийтгүүлсэн шалтгаан, нөхцлийг судлах.
3. Гэмт хэрэгт холбогдох үеийн хөдөлмөр эрхлэлтийн байдал.
4. Ял эдлэгсдийн 0-18 насны хүүхдүүдийн талаарх мэдээлэл.
5. Ялтнуудын хөдөлмөр эрхлэлт.

Судалгаанд Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял эдэлж буй 103 ялтан хамрагдав. Тэдгээрийн 45 нь чанга дэглэмтэй, 58 нь жирийн дэглэмтэйгээр ялаа эдэлж байв.


**Гурав. Судалгааны дэлгэрэнгүй**

1. Судалгаанд хамрагдагсдын нас, хэргийн зүйл анги, шүүхээс ногдуулсан ялын хэмжээ, ял эдэлсэн хугацаа зэрэг хувийн мэдээллийн тухай


Судалгаанд тус хорих ангид Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн “Хүнийг санаатай алах” гэмт хэргээр шийтгэгдэн ял эдэлж буй эмэгтэй ялтнууд хамрагдав.

Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн бол 10-аас дээш 15 жил хүртэл хугацаагаар хорих ял, мөн зүйлийн 91.2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг санаатай алах гэмт хэргийг үйлдсэн бол 15-аас дээш 25 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэхээр хуульд заасан бөгөөд судалгаанд хамрагдсан нийт эмэгтэй ялтнуудын 42% нь буюу 43 хүн Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн нь шүүхээр тогтоогдон ял эдэлж байна. Харин 54% буюу 56 хүн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт шийтгэгдэн ял эдэлж буй бол үлдсэн 4% нь хуучин Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд заасан хүнийг санаатай алах гэмт хэрэгт ял эдэлж байна. /Хүснэгт №1/

Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан онц хүнд гэмт хэрэгт ял эдэлж буй эмэгтэйчүүдийн ялын үндсэн хугацаа нь Эрүүгийн хуулийн 55<sup>1</sup>-р зүйл /Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял хорих ял оногдуулах/, 52 дугаар зүйлийн 52.3 /“...тавин таваас дээш насны эмэгтэй, ...-д арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй/-т заасан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй байгаа болно.




Тус хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 46.6% нь ял шийтгүүлэх үедээ 25-35 настай /Хүснэгт №2/ байжээ. Судалгааны явцад авсан санал асуулгаар чанга дэглэмтэй хорих ангид ял эдлэгсдийн 4.4% нь ял шийтгүүлэх үедээ 35-45 настай байсан бол жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэгсдийн 29.3% нь ял шийтгүүлэх үедээ 35-45 настай байсан гэсэн дүн гарч байна. Тодруулбал, 35-45 насандаа ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн 89.4% нь жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байна.




Хүснэгт №2

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 36.8% нь бүрэн дунд, 32.0% нь бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн байна. Дээд боловсрол эзэмшсэн 8 ялтан байгаа нь нийт ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 7.7 хувийг эзэлж байв. /Хүснэгт №3/



Хүснэгт 3

Нийт ялтны 68.9% буюу 71 ялтны хувьд 0-10 жил хоригдох хугацаа үлдээд байгаа ба 0-5 жилтэй 35, 5-10 жилтэй 36 ялтан байна. 10-15 жил ял эдлэх хугацаа үлдсэн 15 ялтан байгаа нь нийт ялтны 14.5%-ийг эзэлж байна. Харин 5 ялтны хувьд 15-20 жилийн хорих ял эдлэх хугацаа үлдээд байв.




Хүснэгт 4

“Шүүхээс танд оногдуулсан ял шийтгэл, хэргийн зүйл ангийг та хүлээн зөвшөөрдөг үү?” гэсэн асуултад 24 ялтан буюу нийт ялтны 24.4% нь “Тийм” гэж хариулсан ба оногдуулсан ял шийтгэл, хэргийн зүйл ангийг хүлээн зөвшөөрдөггүй гэж 79 хүн буюу 76.6% нь хариулав. Үүнийг лавшруулан “Шүүхээс хэргийг үнэн зөв шийдвэрлэсэн гэж үздэг үү?” гэсэн санал асуулга явуулахад 82 ялтан “Үгүй” гэж хариулсан байна.

Оногдуулсан ялыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа шалтгааныг дурдахдаа ял оногдуулахдаа хохирогчийн буруутай ажиллагааг огт авч үздэггүй, зөвхөн хохирогчийн талын гомдол, гэрчийн мэдүүлэг дээр үндэслэж нотлох баримтыг үнэлдэг, сэжигтэн, яллагдагчийг өмгөөлөх талын нотлох баримтыг хэрэгсдэггүй, өөрөө нотлох баримтаа гаргаж өгөх боломжийг хангадаггүй, гэмт хэрэг үйлдсэн гэх нотлох баримт хангалтгүй байхад ял тулгасан, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхийн шатанд заавал яллах талыг баримталж байцаан шийтгэх ажиллагааг явуулдаг, огт хийгээгүй гэмт хэрэгт ял шийтгэсэн, авах ёстой ялаас хүнд ял тулгасан, өмгөөлөгчийн туслалцаа авах эрхийг хаан боогдуулсан, аргагүй хамгаалалтын нөхцөл байдлыг шүүх чаддаггүй гэх гомдлыг гаргаж байв. Нийт 103 ялтны 28 /27.1%/ нь огт хүн амины гэмт хэрэг үйлдээгүй гэж хариулжээ.

Гэмт хэргийн хохирогчдийн 43% нь ялтны нөхөр, хамтран амьдрагч, төрөл садны хүн биш гэсэн судалгааны дүн гарч байна. Нөхөр, хамтран амьдрагчаа хөнөөсний улмаас ял шийтгүүлж байгаа гэх эмэгтэйчүүд 39 буюу 37%-ийг эзэлж байна. /Хүснэгт №5/






Хүснэгт 5

Судалгаагаар ялтнуудын нас, хэргийн зүйл анги, шүүхээс ногдуулсан ялын хэмжээ, ял эдэлсэн хугацаа зэрэг хувийн мэдээллийг тодруулах ажил хангалттай түвшинд хийгдсэн гэж үзэж байна.

## 2. Гэмт хэрэгт шийтгүүлсэн шалтгаан, нөхцөл

Шүүхээс оногдуулсан ялыг хүлээн зөвшөөрдөггүй ялтнууд 79%-ийг эзэлж байгаа /тэдгээрийн дунд огт хүн амины гэмт хэрэг үйлдээгүй гэж үздэг хүмүүс ч бий/ ч “Та ямар шалтгааны улмаас хүний амь насыг хохироох болсон бэ?” гэсэн асуултад бүгд хариулсан байна. Эдгээрийг Хүснэгт №6-д харуулав.




Хүснэгт 6

Судалгааны үед ялтнуудтай бүлгийн ярилцлага хийх үед гэмт хэрэг үйлдэхээс аргагүй байдалд хүргэсэн нөхцлийг дурдахдаа, хохирогчийн зүгээс сэтгэл санааны хүнд дарамтад байлгадаг, хүчирхийлдэг, байнга согтуурч, агсам тавьдаг, хүчиндэхийг оролдсон гэх мэт шалтгааныг дурдаж байв. Ихэнх нь аргагүй хамгаалалтын үүднээс хүний амь нас хөнөөсөн гэж тайлбарлаж байв. Тухайн гэмт хэргийг үйлдэгдэхээс өмнө аливаа дарамт, хүчирхийлэлд өртөж буй талаар хуулийн байгууллагад мэдэгдсэн гэх ялтан 23 буюу нийт ялтны 22.3%-ийг, гэр бүл цуцлуулах саналыг шүүхэд гаргаж байсан гэх ялтан 10 буюу нийт ялтны 9.7%-ийг тус тус эзэлж байв.


Гэмт хэрэгт шийтгүүлсэн шалтгаан, нөхцлийг тогтоох судалгааны дүнгээс үзвэл энэхүү нөхцөл байдал өргөн хүрээг хамарч байна.

### 3. Гэмт хэрэгт холбогдох үеийн ажил эрхлэлтийн байдал, орлогын эх үүсвэр, амьдралын түвшингийн тухай

Ялтнуудын 30.0% нь хэрэгт холбогдох үедээ ажил хөдөлмөр эрхэлдэг байсан гэж хариулжээ. 27.1% нь тодорхой эрхэлсэн ажилгүй, харин 42.7% буюу 44 хүн эрхэлсэн ажилгүй ч хувиараа хөдөлмөр эрхэлж, орлого олдог байсан гэж санал асуулгад хариулжээ. /Хүснэгт №7/ 66.9% нь гэмт хэрэгт холбогдох үедээ дундаж орлоготой байсан гэснийг сонгосон байв. /Хүснэгт №8/



Хүснэгт 7



Хүснэгт 8


Тухайн этгээдийн гэмт хэрэгт холбогдох үеийн өрхийн орлогыг нарийвчлан тогтооход хүндрэлтэй байсан бөгөөд ял эдэлж буй ялтнууд өөрсдийн орлогын

хэмжээг тодорхойлж мэдэхгүй байх явдал гарч байсан тул сайн, дунд, муу гэсэн ерөнхий үзүүлэлтээр санал асуулга явуулав.

#### 4. Ялтнуудын хүүхдийн талаарх судалгаа

Уг судалгаагаар ялтнуудын 0-18 насны хүүхдүүдийн талаарх мэдээллийг нарийвчлан судалж, сургууль завсардсан эсэх, мэргэжлийн болон их дээд сургуульд хамрагдсан эсэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэх, одоо хэний асрамжид байдаг, асран хамгаалагчийг албан ёсоор тогтоож өгсөн эсэх, хүүхэдтэйгээ уулздаг эсэхийг тодруулахыг зорилоо.

Ялтнуудын 73.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэдтэй байв. /Хүснэгт №9/



Хүснэгт 9

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхэд энэ үед хаана, хэний асрамжинд амьдарч байгааг тодорхойлох судалгааны үр дүнг Хүснэгт №10-т үзүүлэв. 103 ялтнаас 85 нь уг судалгаанд хамрагдав. Судалгаанд хамрагдагсдаас 53 хүн хүүхэдтэйгээ уулздаг гэсэн бол 18 нь огт уулзаж чаддаггүй гэж хариулав. Хүүхэддээ шоронд ял эдэлж байгаагаа мэдэгдэхийг хүсэхгүй байх, эсвэл авчирч уулзуулах хүн байдаггүй учраас уулзаж чаддаггүй байна. Шүүхийн шийтгэх тогтоолд ялтны 18 насанд хүрээгүй хүүхдийг хэрхэх тухай заадаггүй гэж хүүхэдтэй олонхи ялтан тайлбар өгч байлаа. Жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж буй 18 насанд хүрээгүй хүүхэдтэй ялтнуудаас шүүхийн шийтгэх тогтоолд хүүхдийн асуудлыг дүүргийн Засаг даргад нь хариуцуулсан тохиолдол нэг удаа гарсан гэж хариулсан болно.

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН



Хүснэгт 10


Тухайн ялтныг хорих ял эдэлж байх хугацаан дахь тэдгээрийн хүүхдүүдийн боловсрол эзэмшсэн байдлыг тодруулах, сургууль завсардалт гарсан эсэхийг тогтоох зорилгоор 2 шатны санал асуулгын судалгаа явуулав.

Үүнд, нэгдүгээрт, ял эдлэх хугацаанд ерөнхий боловсролын дунд сургуульд суралцаж байсан хүүхдүүдийн сургууль завсардсан байдлыг тодруулах /Хүснэгт №11/, мөн хугацаанд ялтнуудын хүүхдүүд их, дээд сургуульд суралцаж чадсан эсэхийг тодруулах /Хүснэгт 12/ ажиллагаа явуулав.

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүд ерөнхий боловсролын сургуулиас засвардах явдал өндөр түвшинд байгаа нь судалгаагаар тогтоогдож байна. Уг судалгаанд 73 ялтан хамрагдсан ба тэдгээрийн 31 нь буюу 45.9% нь хүүхэд нь сургуульд сурч байгаад дундаас нь завсардсан гэж хариулжээ. Хүүхэд нь сургуульд огт сураагүй ялтны тоо 15 буюу судалгаанд хамрагдсан ялтнуудын 20.5%, хүүхэд нь сургуульд сурч төгссөн ялтны тоо 14 буюу судалгаанд хамрагдсан ялтнуудын 19.1%, хүүхэд нь сургуульд сурч байгаа ялтны тоо 13 буюу 17.8%-ийг эзэлж байна.

Дунд сургуулиас завсардсан болон сургуульд суралцаж чадаагүй шалтгааныг дурдахдаа санхүүгийн боломж байхгүй, ар гэрийн амьдрал хүнд, ажил хийж мөнгө олох хэрэгтэй болсон, харж хандах хүн байхгүй гэж байв.






Хүснэгт 11

Ялтны хүүхдүүдийн мэргэжлийн болон их, дээд сургуульд элсэн суралцсан байдлын судалгаанд нийт 32 ялтан хамрагдав.

Ял эдэлж байх хугацаанд хүүхдүүд нь мэргэжлийн болон, их, дээд сургуульд суралцаж төгссөн гэж 14 ялтан буюу судалгаанд хамрагдагсдын 43.7%, огт сураагүй гэж 12 ялтан буюу судалгаанд хамрагдагсдын 37.5%, сурч байсан боловч төгсөөгүй гэж 4 ялтан буюу судалгаанд хамрагдагсдын 12.5%, сурч байгаа гэж 2 ялтан буюу судалгаанд хамрагдагсдын 6.2% нь хариулжээ. Тус хорих ангид ял эдэлж буй 103 ялтнаас 71 нь уг судалгаанд хариулаагүй болно.



Хүснэгт 12

Ялтнуудаас ял эдэлж байх хугацаанд хүүхдүүд нь гэмт хэрэгт холбогдсон эсэх судалгаа авахад 2 хүн “Тийм” гэж хариулжээ. /Хүснэгт №13/ Мөн баривчлах, цагдан хорих, ял оногдуулах үед шүүхээс болон захиргааны байгууллагаас таны хүүхдийг асран хамгаалах талаар шийдвэр гарч байсан эсэх талаар санал асуулга явуулахад 29 хүн /28.1%/ “Тийм”, 50 хүн /48.5%/ “Үгүй” гэж хариулсан бол бусад нь буюу 24 хүн /23.3%/ уг санал асуулгад хариулаагүй байна.



Хүснэгт 13

Тухайн ялтныг баривчлах, цагдан хорих, түүнд ял оногдуулах үед шүүхээс болон захиргааны байгууллагаас хүүхдийг асран хамгаалах талаар шийдвэр гарч байсан эсэхийг тодруулахад 48.8 хувь нь тийм шийдвэр гарч байгаагүй гэсэн бол, 24.4 хувь тийм шийдвэр гарч байсан гэж хариулжээ. Харин 26.6 хувь энэ асуултад хариулаагүй болно.

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 66.6 хувь хүүхэдтэйгээ уулздаг гэж хариулжээ.


/Ялтнуудын хорих ангид байх хугацааны хөдөлмөрийн хөлсийг хүүхэддээ зарцуулдаг эсэх талаархи судалгааны дүнг Хүснэгт №16-д харуулсан болно./

Судалгааны дүнгээс үзвэл шүүхээс насанд хүрээгүй бага насны хүүхэдтэй эхэд ял шийтгэхдээ хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхгүй орхих явдал багагүй хэмжээгээр гардаг байж болзошгүй байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна” гэсэн нь бий.

##### 5. Ялтнуудын хөдөлмөр эрхлэлт

Судалгаагаар ялтны хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хөлсөө авч байгаа байдал, түүний зарцуулалт, хүүхэддээ зарцуулах боломжтой эсэхийг судлав.

Нийт ялтны 78.6% нь тус хорих ангид ял эдлэх хугацаандаа хөдөлмөр эрхэлж байна. /Хүснэгт №14/



Хүснэгт 14

Хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсийг нэрийн дансанд нь шилжүүлдэг гэж 54% нь хариулсан бол, 9.0% нь бэлнээр авдаг, 18% нь хөдөлмөрийн хөлсөө огт авч чаддаггүй гэж хариулжээ. Харин ялтнуудын 19% нь уг асуултад хариулаагүй байна.




Хүснэгт 15

Ялтнуудын дунд хөдөлмөрийн хөлсөө үр хүүхэддээ зарцуулах боломжтой эсэх талаар судалгаа явуулахад доорхи үр дүн гарав.

Нийт 103 ялтны 20 нь хөдөлмөрийн хөлсөө хүүхэддээ зарцуулах боломжтой гэсэн бол, 58 нь тийм боломж байдаггүй гэж хариулсан болно. Харин уг судалгаанд 24 ялтан хариулаагүй байна. Үүнийг хувьд шилжүүлбэл /Хүснэгт №16/,

### Хөдөлмөрийн хөлсөө хүүхэддээ зарцуулдаг эсэх



Хүснэгт 116

Боломжгүй гэж хариулсан ялтнуудаас шалтгааныг тодруулахад, хөдөлмөрийн хөлс хэтэрхий бага учир хүүхэддээ зарцуулж хүрдэггүй гэж дийлэнх нь хариулсан бол бусад нь хүүхэдтэйгээ уулзах боломж байдаггүй, хохирлын төлбөрт суутгаад дуусдаг, хөдөлмөрийн хөлс огт өгдөггүй, нэрийн дансгүй гэсэн тайлбарыг мөн хэлж байлаа.

### Дөрөв. Судалгааны үр дүнд цаашид авах арга хэмжээний талаар

Тус ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хувьд 87 эмэгтэй буюу судалгаанд хамрагдагсдын 84.5 хувь нь гэмт хэрэгт холбогдох үедээ ид хөдөлмөрлөх, хийж бүтээх, үр хүүхэд гаргах, өсгөж хүмүүжүүлэх 18-45 настай байсан байна. Гэтэл тэд шүүхээс 10-25 жилийн хорих ялаар шийтгүүлж байгаа нь эмэгтэй хүний хувьд хүндэдсэн ял шийтгэл гэж үзэж байна. Тиймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт “тавин таваас дээш насны эмэгтэй” гэснийг “эмэгтэй” гэж хуульд өөрчлөлт оруулах талаар нөлөөллийн ажил зохион байгуулах,

Тус ангид ял эдэлж байгаа эмэгтэйчүүдээс Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 93 дугаар зүйл санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах, 94 дүгээр зүйл бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэгт шийтгүүлсэн хүн байхгүй байсан ба Хүнийг санаатай алах гэмт хэрэгт шийтгүүлсэн 103 эмэгтэй байв. Шүүхийн практикт гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой, ялангуяа эмэгтэй хүний үйлдсэн хүн амины хэрэгт аргагүй хамгаалалт, сэтгэл санааны хүчтэй цочрол, гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийг сайтар нягтлах, мөрдөн байцаалтаар заавал тогтоолгох талаар сургалт зохион байгуулах,

Баривчлах, хорих ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн насанд хүрээгүй хүүхдүүдэд шүүхээс асран хамгаалагч заавал тогтоож өгч байхаар шүүхийн практикт нэг мөр болгох,

Ял эдлэх хугацаанд үр хүүхэдтэйгээ тодорхой хугацаанд уулзаж байх боломжийг оршин суугаа газрын төрийн захиргааны байгууллагаас бүрдүүлдэг тогтолцоог бий болгох,

Ял эдэлж байгаа хүний хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг хүлээсэн этгээд тус үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих тогтолцоог бий болгох /Учир нь ял эдэлж буй эмэгтэйчүүд бүлгийн ярилцлагын үеэр энэ талаар маш их гомдол мэдүүлж байсан/,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ялтны хөдөлмөр эрхлээд олсон ажлын хөлснөөсөө насанд хүрээгүй хүүхдийнхээ боловсрол, ахуйн хэрэгцээнд зарцуулах боломжийг бий болгох,

Дээрх саналуудтай холбоотойгоор шаардлагатай байгууллага, албан тушаалтанд санал тавих, хамтран ажиллах, зөвлөмж хүргүүлэх ажлыг Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийж болохоор байна.

ХЯНАСАН:

ХЭҮК-ЫН ГИШҮҮН

Ж.ДАШДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

Б.БАТАА

Т.ИХТАМИР

Г.АГАР-ЭРДЭНЭ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН